

Төв аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2014 оны 7 дугаар сарын байдлаар)

I. Нийгмийн үзүүлэлт




I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн.

2014 оны 7 дугаар сард Хөдөлмөрийн хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1050 болж, 2013 оны мөн үеэс 484 хүнээр, өмнөх сарынхаас 86хүнээр тус тус өсөв.

Ажилгүйчүүдийн 51,9 хувь буюу 545 нь эмэгтэйчүүд юм. 2014 оны эхнээс 1180 ажлын байр захиалгад бүртгэгдсэнээс 751 ажлын байранд иргэд зуучлагдан ажилд оров. Ажилд зуучлагдсан иргэдийн 35.95 хувь буюу 270 нь эмэгтэйчүүд байна.

Зураг I.1

Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 7 дугаар сарын эцсийн байдлаар




Тайлант сард бүртгүүлсэн 52 ажилгүй иргэний 34,6 хувь нь сургууль төгссөн, чөлөө авсан, 17,3 хувь нь өрхийн болон хувийн аж ахуй эрсдэлд орж орлогогүй болсон, 15,4 хувь нь өөр газраас шилжин ирсэн, 15,4 хувь нь одоо эрхэлж буй ажлаа солих хүсэлтэйбайгаа, 3,8 хувь нь гүйцэтгэж буйажилалбан тушаалдаа тэнцэхгүй болсон, 3,8 хувь нь цэргээс халагдсан, 1,9 хувь нь байгууллага татан

буугдсан, 1,9 хувь нь гадаадаас эргэж ирсэн, 5,8 хувь нь бусад шалтгаанаар бүртгүүлжээ.

Ажилгүйчүүдийг боловсролын төвшинээр хуваавал 21,87% нь дээд; 10,56% нь тусгай дунд; 10,75% нь мэргэжлийн анхан шатны; 37,48% нь бүрэн дунд; 15,23% нь бүрэн бус дунд боловсролтой; 4,11% нь бага буюу боловсролгүй иргэн байна.

Зураг I.2

Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 7 дугаар сарын эцсийн байдлаар



Эх үүсвэр: Хөдөлмөрийн хэлтсийн сар бүрийн мэдээ

*- Ажил хайгч гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн иргэнийг ойлгоно.



I.2 Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 7 сард НДШ-ийн орлого 7595.7сая ₮ болж төлөвлөгөө 84.82 хувь боллоо, төлөвлөгөөг Борнуур сум 102.24 хувиар биелүүлж бусад сум 7.48 - 20.55 хувиар тасалдууллаа. Сайн дурын НДШ-ийн орлого 346.2 сая ₮ болж

төлөвлөгөө 84.60 хувь болж, бүх сум 1.53-34.12 хувиар тасалдууллаа.

Тэтгэвэр, тэтгэмжинд 17544.6 сая ₮ зарцуулж, олголт 100.0 хувь боллоо. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийн 80.0 хувийг өндөр настны, 11.0 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 4.0 хувийг тэжээгчээ алдсаны, 5.0 хувийг цэргийн тэтгэвэрт тус бүр зарцуулжээ.

Нийгмийн даатгалын сангаас олгосон дундаж тэтгэвэр 226190 ₮ боллоо.

Нийгмийн даатгалын нийт зарлагын 38.37% хувийг орлогоороо бүрдүүлснээс тэтгэврийн даатгалын сангийн 28.82%; тэтгэмжийн даатгалын сангийн 100.90%; эрүүл мэндийн даатгалын сангийн 75.05%; үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалах өвчний даатгалын сангийн 195.11 %; ажилгүйдлийн даатгалын сангийн 149.48 %-ийг тус бүр бүрдүүлжээ.

Нийгмийн халамж

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн мэдээгээр 2014 оны эхний 7 сард нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг 115538 хүнд олгож, 6.2 тэрбум ₮-ийг зарцуулж 2013 оны мөн үеэс хүний тоо 1.4 дахин 67514 хүнээр, зарцуулсан мөнгөний хэмжээ 39.30 хувь 1.76 тэрбум ₮-өөр өслөө.

Нийгмийн халамжийн дундаж тэтгэвэр 105140 ₮ болжээ. Олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламжийн 31.33 хувийг хүүхдийн хөгжил сангийн мөнгө; 25.65 хувийг халамжийн тэтгэвэр; 9.98 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн мөнгөн тэтгэмж; 6.20 хувийг төрөл бүрийн нөхцөлт мөнгөн тусламж; 2.33 хувийг нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж; 4.05 хувийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд нийгмийн хамгааллын хуулийн дагуу олгогдож байгаа хөнгөлөлт, тусламж; 0.97 хувийг алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламжид тус бүр зарцуулжээ.




1.3 Эрүүл мэнд

2014 оны эхний 7 сард 9524 өвчтөн эмнэлэгт хэвтэн эмчлэгдэн гарсан нь нэг өвчтөнд дунджаар 7.9 ор хоног ногдлоо.

Эрүүл мэндийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 7 сард 796 хүүхэд мэндэлсэн нь 2013 оны мөн үеэс 114 хүүхдээр өслөө.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар.



Аймгийн хэмжээнд 2014 оны эхний 7-н сард нялхсын эндэгдэл 5 хүүхэд гарч өмнөх оны мөн үеэс 1-ээр буурсан байна.

5 хүртлэх насандаа эдсэн хүүхэд гараагүй ба өмнөх оны мөн үед харьцуулвал 50 хувиар буюу 1 хүүхдээр буурсан байна.

Зураг 1.4


Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



2014 оны эхний 7 сард нийт гарсан халдварт өвчнөөр 294 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 32.3 хувь буюу 140 хүнээр буурлаа. 2013 оны мөн үеэс трихомениаз 2.8 дахин, заг хүйтэн 1.4 дахин, тэмбүү 1.1 дахин тус бүр өсчээ. 10000 хүнд ногдох өвчлөл аймгийн дундаж 33 байгаа бол: Зуунмод 91, Сүмбэр 70, Мөнгөнморьт 50, Сэргэлэн 38 ногдлоо.

Зураг 1.5

10000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



1.4 Байгаль орчин

Цаг агаарын тойм, агаарын бохирдол

- агаарын дундаж температур 15-21 градус дулаан буюу Өндөрширээт, Борнуур, Лүн, Баянцагаан, Баянжаргалан Цээл, Заамар орчмоор дулаан, нутгийн зүүн хойд хэсэг буюу Мөнгөнморьт орчмоор сэрүүвтэр

- өдөр ажиглагдсан агаарын хамгийн дулаан температур нь 28-35 градус буюу хамгийн их нь Бүрэн, Өндөрширээтэд 34 градус, Борнуур, Баян-Өнжүүлд 35 градус хүрч, ихэнх нутгаар хэт халалтын хэмжээнд хүрч халсан, нутгийн зүүн хэсгээр сэрүүвтэр, үүнээс Мөнгөнморьт орчмоор 28 градус дулаан байв.

- шөнийн хугацаанд ажиглагдсан хамгийн бага температур нь 2-10 градус буюу Заамар, Нөхөрлөл, Лүн, Өндөрширээт орчмоор 8-10 градус дулаан, нутгийн зүүн хойд хэсгээр сэрүүвтэр, хамгийн сэрүүн нь Мөнгөнморьтод 2 градус, Эрдэнэд 3 градус дулаан хоолоо.

- бүх нутгаар нийлбэр хур тунадас 26,2-159,2 мм буюу Баян-Өнжүүлд 26,2 мм хамгийн бага нь, нутгийн зүүн болон хойд хэсгээр ахиухан, үүнээс хамгийн их нь Мөнгөнморьтод 159,2 мм бороо оржээ.

- салхины их хурд ихэнх нутгаар 6-11 м/с, борооны өмнө зарим газраар 12-14 м/с, түр зуур 16-18 м/с, нөөлөг 20-23 м/с хүрч ширүүслээ. Мөндөр, ширүүн аадар бороо, нөөлөг салхиар зарим газар аюултай үзэгдлийн мэдээ өгсөн. Ихэнх нутгаар олон жилийн дунджаас ахиу бороо оржээ.

Сарынхаа ихэнх хугацаанд салхи шуурга харьцангуй багатай, нийт нутгуудаар зуншлага сайн .

Төв аймгийн нутгаар. Агаарын температурын сарын дундаж нь 15-20 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байх төлөвтэй.

Сэрүүсэх хугацаа: Нэг, гуравдугаар арав хоногийн дунд ба сүүлчээр, хоёрдугаар арав хоногийн дундуур сэрүүсч уулархаг нутгаар шөнөдөө 3 градус хүйтнээс 2 градус дулаан, хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд ба сүүлчээр хөрсөн дээр 0-5 градус хүрч цочир хүйтэрнэ, өдөртөө 9-14 градус, бусад нутгаар шөнөдөө 5-10 градус, өдөртөө 15-20 градус дулаан.

Харьцангуй дулаарах үе: Нэг, хоёрдугаар арав хоногийн эхээр Туул голын сав, болон тал хээрийн нутгуудаар шөнөдөө 10-15 градус, өдөртөө 27-32 градус хүрч дулаан байх төлөвтэй

Бусад хугацаанд: Уулархаг нутгаар шөнөдөө 4-9 градус, өдөртөө 16-21 градус, бусад нутгаар шөнөдөө 9-14 градус, өдөртөө 21-26 градус дулаан байна.

Энэ сард Төв аймгийн баруун хойд хэсгээр олон жилийн дунджаас ахиу, бусад нутгаар дунджийн орчим бороо орох төлөвтэй. Дундаж нь ихэнх нутгаар 40-70 мм орчим, нутгийн хойд хэсгийн зарим газраар 70-90 мм орчим байдаг.


Нэг, гуравдугаар арав хоногийн дунд ба сүүлчээр, хоёрдугаар арав хоногийн дундуур ихэнх нутгаар бороо орно. Харин нэг, гуравдугаар арав хоногийн эхээр зарим газраар, хоёрдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Борооны өмнө салхи түр зуур ширүүснэ, ялангуяа нэгдүгээр арав хоногийн сүүлч, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд үеэр зарим газраар түр зуур 16 м/с хүрч ширүүсч болзошгүй.



1.5 Гэмт хэрэг

Цагдаагийн байгууллагын мэдээгээр 2014 оны эхний 7 сард аймгийн хэмжээнд 572 гэмт хэрэг бүртгэгдэж 422 хүн холбогдож төр, иргэдийн өмчид 1566.4 сая ₮-ийн хохирол учирлаа.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар



Зураг 1.9

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн 7 дугаар байдлаар



Гарсан гэмт хэргийн 39.8 хувь нь хулгай, 26.19 хувь нь иргэний эрүүл мэнд эрх чөлөөний -ний хэрэг, 11.31 хувь нь бусад хэрэг. 16.6 хувь нь замын осол, 4.7 хувь нь танхай дээрэм, 1.19 хувь нь хүний амийн хэрэг тус бүр эзлэв. Сэргэлэн, Аргалант, Баяндэлгэр, Лүн, Эрдэнэ, сумдад 10000 хүнд 279-104 гэмт хэрэг ногдсон нь аймгийн дунджаас (65)-аас харьцангуй их байна.

Гэмт хэргийн тоо 2013 оны мөн үеэс 48 хэргээр өслөө.


Зуунмод суманд 31, эмэгтэй 690 эрэгтэй нийт 721 хүн эрүүлжүүлэгдсэн нь 2013 оны мөн үеэс 41 хүнээр буурлаа.



Шүүхийн шийдвэр гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны эхний 7 сарын мэдээгээр ажиллагаа хийгдэж байгаа

1206 гүйцэтгэх хуудсанд нийт 3360.1 сая₮-ийн төлбөр тэтгэлэг ногдов. Үүнээс 488 гүйцэтгэх хуудсанд ногдох 603.5 сая₮-ийн материалд шүүхийн байцаан шийтгэх ажиллагаа хийгдэж, биелүүлбэл зохих 718 гүйцэтгэх хуудасны 2756.6 сая₮-өөс 322 хуудасны 1280.4 сая₮-ийг биелүүлж, бодит биелэлтийн хувь гүйцэтгэх хуудасны тоогоор 44.85 хувь, үнийн дүнгээр 46.45 хувь болж 2013 оны мөн үеэс гүйцэтгэх хуудасны биелэлт 11.59 нэгжээр, үнийн дүнгийн биелэлт 19.08 нэгжээр тус тус өслөө.



II. Эдийн засгийн үзүүлэлт



II.1 Мөнгө, зээл, хадгаламж

ХААН, Хадгаламж, Хас банкны салбаруудын дүнгээр 2014 оны эхний 7 сард кассын орлого 405.0 тэрбум ₮, кассын зарлага 403.6 тэрбум ₮ болж, гүйлгээнд 2.3 тэрбум ₮ байна.

ХААН, Хадгаламж, Хас банкны салбарууд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад жижиг худалдаа, үйлдвэрлэлийг дэмжих үүднээс бичил

бизнес болон нийт олгосон зээлийн үлдэгдэл 7 сарын 31-ний байдлаар 111.6 тэрбум ₮, байгаа нь өмнөх оны эцсээс 20.6 тэрбум ₮-өөр өслөө.

2014 он гарсаар Засгийн газраас бичил бизнесийг дэмжих ажлын хүрээнд зээлдэгч нарт 80.2 тэрбум төгрөгийн зээл олгожээ. Иргэдийн хувийн хадгаламжинд 7 сарын 31-ний байдлаар 36.7 тэрбум ₮ байна.

Харилцах дансны үлдэгдэл 7 сарын 31-ны байдлаар 286983 иргэний 11.3 тэрбум ₮ боллоо.

ХААН, Төрийн, Хас банкны салбарууд иргэдийн хадгаламжинд төлж байгаа хугацаатай дээд хүү 1.19-1.34 хувь, хугацаатай доод хүү 0.62-0.65 хувь, хугацаагүй хадгаламжийн хүү 0.60-0.62 хувьтай байна.



II.2 Төсөв, мөнгө

Төсвийн орлого 2014 оны эхний 7 сард орон нутаг ба аймагт төвлөрүүлснээр орлого 6.5 тэрбум ₮, зарлага 35.7 тэрбум ₮ болж, аймаг, орон нутгийн төсвийн орлогоор тооцоход орлогын төлөвлөгөө 134.6 хувь биелэгдэж, үндсэн нэрийн татварын орлогуудаас: Бууны албан татвар, газрын төлбөр, байгалийн ургамал, бусад төлбөр хураамж, төсөвт газрын өөрийн орлогын төлөвлөгөө биелэгдсэнгүй.

Аймгийн төсвийн орлого 2013 оны мөн үеэс 26.2 хувь буюу 1.3 тэрбум ₮-өөр өслөө. Аймгийн төсвийн орлогын 84.6 хувийг татварын, 14.9 хувийг татварын бус, 0.5 хувийг хөрөнгө борлуулсны орлогууд бүрдүүлж байгаа нь 2013 оны мөн үеэс татварын орлого 5.33 нэгжээр өсч, татварын бус орлого 4.96 нэгжээр, хөрөнгө борлуулсны орлого 0.34 нэгжээр тус бүр буурлаа.

Аймгийн нийт 3 шатны орлого 7.7 тэрбум ₮ болж аймгийнх 5.4 тэрбум ₮ буюу 70.7 хувь, сумынх 1.0 тэрбум ₮ буюу 14.2 хувь, улсынх 1.1 тэрбум ₮ буюу 15.1 хувийг тус бүр бүрдүүлжээ.

2013 оны мөн үеэс төсөвт байгууллагуудын өглөг 21.5 хувь буюу 176.5 сая ₮-өөр буурч 642.7 сая ₮, авлага 28.5 хувь буюу 33.10 сая ₮-өөр буурч 83.3 сая ₮ боллоо.

Орон нутгийн төсвийн орлого 6.4 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 138.7 хувиар биелэгдлээ. Суманд төвлөрүүлэх төсвийн орлого 1.1 тэрбум ₮ болж, төлөвлөгөө 245.6 хувь биелж, Алтанбулаг сум 5.6 хувиар тасалдууллаа.

Аймагт төвлөрүүлэх төсвийн орлогын төлөвлөгөө 5.4 тэрбум ₮ болж 123.47 хувь биелж, Баянжаргалан, Жаргалант, Борнуур, Сүмбэр, Цээл, Баянхангай, Мөнгөнморьт, Өндөрширээт, Угтаал, Батсүмбэр, Эрдэнэсант сумд 34.5-1.4 хувиар тасалдууллаа.




II.3 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

2014 оны 7 дугаар сард ХҮИ /хэрэглээний үнийн индекс/ суурь үе болох 2010 оны 12 дугаар сараас 46,72%, өмнөх оны мөн үеэс 14,09%, өмнөх сараас 0,49 хувиар тус тус өсөв. 7 дугаар сард өмнөх сартай харьцуулахад нийт өрхийн хүнсний хэрэглээнд өндөр хувийн жин эзэлдэг хүнсний ногооны дэд бүлэг 8,91%; талх гурил, будааны дэд бүлгийн үнэ 2,62%; согтууруулах бус ундаа 0.71%; хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 0,21%; саахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр, шоколадны дэд бүлгийн үнэ 0.10%-аар тус тус өсч; мах махан бүтээгдэхүүний

дэд бүлгийн үнэ; жимс жимсгэний дэд бүлгийн үнэ; төрөл бүрийн өөх, тосны дэд бүлгийн үнэ тогтвортой байсан бол сүү сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 1,35%-аар тус буурав.

Зураг II.4
Хэрэглээний үнийн аймгийн индекс
(өмнөх оны 12 сар=100)



Хэрэглээний үнийн индексийн 2014 оны 7 дугаар сарын 0.49 хувийн өсөлтийн 0,36 нэгж (73.1%) нь хүнсний барааны бүлгийн үнийн өсөлтөөс; 0,1 нэгж (21.3%) нь орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 0,04 нэгж (8,21%) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс; 0,03 нэгж (5,79%) нь эм тариа, эмнэлэгийн үйлчилгээний үнийн өсөлтөөс 0,01 нэгж (1,42%) нь бусад бараа үйлчилгээний бүлгийн үнийн өөрчлөлтөөс тус тус шалтгаалсан байна.

Зураг II.5 Үйлдвэрлэл, мод, модон эдлэлийн үйлдвэрлэл, төмрийн үйлдвэрлэл өмнөх оноос 15 дахинаас-8.7хувь буюу 3.4 тэрбум-2.6 сая ₮-өөр өссөн нь нөлөөлөв.

Инфляцийн өсөлтөд үзүүлсэн бүлгүүдийн нөлөөлөл

Бараа, үйлчилгээний бүлэг	2014 оны 7-р сард	
	пунктээр	хувиар
Бүгд	0.49	100.00%
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	0.36	73.13%
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	0.00	0.00%
03. ХУВЦАС, БЭС БАРАА, ГУТАЛ	0.04	8.21%
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	0.10	21.30%
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	0.00	0.00%
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	0.03	5.79%
07. ТЭЭВЭР	0.00	0.00%
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	-0.05	-9.85%
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	0.00	0.00%
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	0.01	1.42%



II.5 Аж үйлдвэр

2014 оны эхний 7 сард (2005 оны зэрэгцүүлсэн үнэнд шилжүүлснээр) 7,9 тэрбум ₮-ийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2013 оны мөн үеэс 1,1 дахин буюу 4.2 тэрбум ₮-өөр өслөө. Оны үнээр нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд эзлэх сумдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жингээс үзэхэд Баянцагаан, Зуунмод, Жаргалант, Баянцогт, Баянчандмань, Алтанбулаг, Эрдэнэ, Батсүмбэр, Борнуур сумд 28.7-2.0 (эдгээр сумдын үйлдвэрлэлт 90.29) хувийг эзлэв.

Зураг II.6 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр


АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛТ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр, мян. ₮-р
GROSS INDUSTRIAL OUTPUT, by division, at constant prices of 2005 / mln tog/

АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР INDUSTRIAL SECTOR	2013 VII	2014 VII	2013 I-VII	2014 I-VII	Дүнд зэлэх % Percentage share to total	
					2013 I-VII	2014 I-VII
Нийт дүн	252.81	1,189.30	3,714.14	7,945.58	100.0	100.0
Ашигт малтмал олборлолт mining and quarrying	36.15	473.98	508.94	3,928.37	13.70%	49.44%
Боловсруулах аж үйлдвэр / manufacturing/	215.87	714.59	1,933.86	3,028.14	52.07%	38.11%
Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл Electricity, thermal energy, steam	0.79	0.73	1,271.34	989.06	34.2%	12.45%

Аймгийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөн нь ашигт малтмал олборлолт, архи, ундаа үйлдвэрлэл, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэлийн үйлдвэрлэл, арьс шир боловсруулах, үслэг арьс боловсруулалт, ширэн эдлэл, гутал


Зураг II.6

Боловсруулах аж үйлдвэрийн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр



Оны эхний 7 сарын нийт үйлдвэрлэлтэнд дулааны эрчим хүч 12.5, боловсруулах үйлдвэрлэл 38.1, уул уурхайн үйлдвэрлэл 49.4 хувийг тус тус эзлэв.

Зураг II.7 Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, хувиар



II.6 Барилга


Төв аймгийн барилгын гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллага болон иргэд 2014 оны эхний 7 сард 2706,8 сая ₮-ийн барилга

угсралт, их засварын ажил гүйцэтгэлээ. Гүйцэтгэлийг 2013 оны мөн үетэй харьцуулахад 50,45 хувь буюу 907,9 сая ₮-өөр өсөв. Барилга угсралт их засварын ажлын 22,13 хувь нь орон сууцны барилгад; 50,92 хувь нь орон сууцны бус барилгад; 26,95 хувь нь инженерийн барилга байгууламжид ногдож байна. Энэ нь 2013 оны мөн үетэй харьцуулахад орон сууцны барилгын ажил 15,57 пунктээр; орон сууцны бус барилгын ажил 5,39 пунктээр тус тус өсч, инженерийн барилга байгууламжийн ажил 20,96 пунктээр буурсан үзүүлэлт юм.

Барилгын салбарт ажиллагсадын тоо 2013 оны мөн үеэс 79 хүнээр буурч, цалингийнсан 132,9 сая₮-өөр өсөв.

Зураг II.8

Барилгынажлынгүйцэтгэл, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр



II.7 Холбоо

Холбоо ашиглалтын орлого оны эхний 7 сард 156.9 сая ₮ болж, үүнээс хүн амаас орсон орлого 74.6 сая ₮ болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад 20.1 хувь буюу 26.7 сая ₮-өөр өслөө.

Шуудан холбооны албаны үйлчилгээний орлого 54.9 сая ₮ болж, нийт орлогын 79 хувь нь хүн амд үйлчилсэний орлого байна. Нийт орлогын 21.22 хувийг албан бичгийн, 14.67 хувийг зорчигчдийн, 64.11 хувийг бусад орлого эзлэв.

Зураг II.10
Холбоо ашиглалтын орлого, жил бүрийн 7 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

